



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ЯАМ

“ХАРИУЦЛАГАТАЙ НҮҮДЭЛЧИД” БЭЛЧЭЭРИЙН МАА-Н ЗОХИСТОЙ ДАДЛЫГ НЭВТРҮҮЛЭХЭД ТАВИХ ШААРДЛАГУУД

MNS 6891:2025 стандарт



ЗОРИЛГО

МАЛ, АМЬТНЫ ТАВЛАГ БАЙДЛЫН ТАВАН ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХ, МАЛ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ТОГТВОРТОЙ ЭРХЛЭХ, БЭЛЧЭЭРИЙН МАЛ АЖ АХУЙН АНХАН ШАТНЫ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ТҮВШИНД ХАРИУЦЛАГАТАЙ НҮҮДЭЛЧИД ТОГТОЛЦООГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЗАРЧИМ, ШААРДЛАГА, ШАЛГУУРУУДЫГ ТОГТООХ, ТЭДГЭЭРИЙГ ҮНЭЛЭХ, БАТАЛГААЖУУЛАХАД ОРШИНО.

Хариуцлагатай нүүдэлчид зохистой дадал гэж бэлчээр ашиглах, малын арчилгаа маллагааг хангах, үржүүлэг, селекцийг удирдан явуулах, эрүүл мэндийг хамгаалах болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэхэд тавих шаардлага, шалгуурыг хангахад зориулагдсан цогц үйл ажиллагааг хэлнэ.


СТАНДАРТЫН ХЭРЭГЛЭЭ

Энэхүү стандарт нь Монгол орны бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэхэд мал, амьтны эрүүл мэндийг хамгаалж, тавлаг байдлыг хангах, байгаль орчин, бэлчээр, тэжээл, усны хангамжийг зөв зохистой ашиглах, малын үржүүлэг селекц, тэжээллэг, арчилгаа, маллагаа зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэхэд тавих зохистой дадлыг нэвтрүүлэхэд хамаарна.

СТАНДАРТЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Энэ стандартыг тогтвортой, хариуцлагатай Бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч этгээд, сум, баг, малчдын бүлэг, хоршоо, сургалт болон тохирлын үнэлгээний байгууллагуудад хамаарна.

Энэхүү стандарт нь улсын бүртгэлд бүртгэсэн
2021 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн хүчинтэй.



MNS 6891:2020

Үндсэн зарчим:

1. Уламжлалт нүүдлийн мал аж ахуйн арга ажиллагааг нийгэм, эдийн засаг, зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулж боловсронгуй болгож, хариуцлагын тогтолцоог хөгжүүлэх;
2. Хариуцлагатай нүүдэлчид зохистой дадлыг нэвтрүүлэхдээ мал аж ахуйн тогтвортой байдлыг хангах, малчид, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчид, хэрэглэгчид зэрэг оролцогч талууд харилцан итгэлцэл, үнэн зөв мэдээлэлд тулгуурлах;
3. Хариуцлагатай нүүдэлчид зохистой дадлыг сайн дурын үндсэн дээр нэвтрүүлэх бөгөөд хэрэгжилтийн үе шатуудыг үнэлгээ, баталгаажуулалтын үндсэн дээр нийгмийн дунд хүлээн зөвшөөрөгдөх;



Хариуцлагатай нүүдэлчид зохистой дадалд тавих шаардлагууд нь дараах баримт бичгээс бүрдэнэ. Үүнд:

1. Малын бэлчээрт тавих шаардлага
2. Малын арчилгаа, маллагаанд тавих шаардлага
3. Малын эрүүл мэндэд тавих шаардлага
4. Малын үржүүлэгт тавих шаардлага
5. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэлд тавих шаардлага



Хүлээгдэж буй үр дүн:

1. Нүүдлийн мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх;
2. Бэлчээрийн мал аж ахуйн анхан шатны үйлдвэрлэгчийн түвшинд малын тавлаг байдлыг хангах, хариуцлагатай нүүдэлчид тогтолцоог хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн зарчим, шаардлагыг тогтоох;
3. Дэлхийн зах зээлийн хэрэглэгчдийн шаардлагад нийцүүлэн гарал үүсэл тодорхой, байгаль, мал амьтанд ээлтэй, чанартай, хариуцлагатай мал аж ахуйгаас бэлтгэсэн түүхий эдийг баталгаажуулах;
4. Монгол малын гаралтай бүтээгдэхүүний дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх.